



31

МОНГОЛ УЛСЫН
СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ
ТОГТООЛ

2022 оны 12 сарын 15

Дугаар 12

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсэг, Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.5 дахь заалт, Сонгуулийн ерөнхий хорооны даргын 2022 оны А/25 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн дүгнэлт, саналыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Сонгуулийн автоматжуулсан системийн иж бүрдлийг нөхөн бүрдүүлэх асуудлаар судалгаа хийж Хорооны хуралдаанд танилцуулах үүрэг бүхий ажлын хэсгийг хавсралтад дурдсан бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

2. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хорооны нарийн бичгийн дарга /Д.Даваа-Очир/-д даалгасугай.


ДАРГА

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

П.ДЭЛГЭРНАРАН

Д.ДАВАА-ОЧИР

Сонгуулийн ерөнхий хорооны
2022 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн
12 дугаар тогтоолын хавсралт



АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн дарга:

Сонгуулийн ерөнхий хорооны дэргэдэх
Мэдээллийн технологийн төвийн захирал

Нарийн бичгийн дарга

Ажлын албаны
Хуулийн хэлтсийн референт

Гишүүд:

Сонгуулийн ерөнхий хорооны дэргэдэх
Мэдээллийн технологийн төвийн
Техник хангамж, засвар үйлчилгээний
хэлтсийн дарга

Ажлын албаны
Мэдээлэл, судалгаа, сургалтын төвийн
ахлах референт

Сонгуулийн ерөнхий хорооны дэргэдэх
Мэдээллийн технологийн төвийн
Захиргаа, санхүүгийн хэлтсийн
Ахлах референт

--oOo--